

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН БАЯРСАЙХАНЫ БЯМБАСҮРЭНГИЙН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025.12.03

Хужирт сум

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1.1: ТӨВ СУУРИН ГАЗРЫН ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ОРЧНЫ АРИУН ЦЭВРИЙГ САЙЖРУУЛЖ, ХОГИЙН ЦЭГИЙГ ТОХИЖУУЛАХ, ХОГ ХАЯГДЛААР БҮРХЭГДСЭН ТАЛБАЙГ БАГАСГАХ ЗЭРЭГ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.1.1	”Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тарих ажлыг зохион байгуулах. АЗД, СЗД-тай байгуулсан гэрээний 9-р бүлгийн 1.1. дэх заалт	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулж мод бутны тоо, амьдралтын хувь 75-аас доошгүй байна.	10 000 мод бут тарьсан	Бүх нийтээр мод тарих хаврын өдрүүдийг зохион байгуулж 10000-аас доошгүй мод бут тарих	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мод бут, суулгац тарих ажлыг 2025 оны 05 дугаар сарын 01-25-ны өдрүүдийн хооронд зохион байгуулж ажилласан. Үүнд: Сумын төвийн засмал зам дагуу болон нийтийн эзэмшлийн талбай дахь нийт 3.6 га-д аймгийн Хөдөлмөр халамжийн газартай хамтран 8 иргэнийг 5 хоног, өдрийн 8 цагаар ажиллуулж, шаардлагатай багаж хэрэгслээр ханган, холбогдох мэргэжилтнүүд заавар, зөвлөгөө өгч, улиас 200, шар хуайс 1800, хайлаас 50 ширхэг, нийт 2050 ширхэг мод бут, суулгацыг тарьсан. “Хужирт Цагаан” ХХК-иас нийгмийн хариуцлагын хүрээнд нийтийн эзэмшлийн талбайд 500 ширхэг мод бут, суулгац нийлүүлсэн. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайдаа дараах	2025.05.01 -2025.11.01	90

					албан байгууллага, айл өрхүүд 5453 ширхэг мод бут, тарьц, суулгацыг тарьсан. Үүнд: Хужирт рашаан сувилал ХХК улиас 210, монос 50 ш, Хужирт цагаан ХХК улиас, шар хуайс, монос, үхрийн нүд, гүйлс, буйлс, хайлаас нийт 4000 ш, Элма Хужирт ХХК алимны 15 ш суулгац, 2 дугаар цэцэрлэг нарс 4ш, монос 3ш, гацуур 3ш, 176 өрх 1277 ширхэг мод бут сөөг, суулгацыг тарьсан. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Жем Хужирт” ХХК нийтийн эзэмшлийн талбайд өмнөх жилүүдэд тарьсан мод бутны хашааг өөрсдийн хөрөнгөөр засаж, өргөтгөн Бүгд Найрамдах Солонгос улсын “Хан-нара” ТББ-аас хандивласан 500 ширхэг нарс модны суулгацыг цаашид арчилан хамгаалж ургуулах ажлыг хариуцахаар болсон. Тус мод бут тарих, модны нүх ухах зэрэг ажилд ИТХ-ын ажлын алба, Иргэдийн Хурлын Төлөөлөгчид, ЗДТГ, ЕБ-ын 1, 2 дугаар сургуулиуд, СӨББ-ууд Соёлын төв, Цаг уур, Цагдаагийн тасаг, Эрэн хайх, аврах бүлэг, Хужирт ус суваг зэрэг байгууллагууд хамтран оролцсон. Сумын хэмжээнд нийт 8412 ширхэг мод бут тарьсан ба модны амьдралын хувь 90 хувьтай байна. Мод бут тарих ажилд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 5500.0 мянган төгрөг, аж ахуйн нэгж, иргэд байгууллага 9425.0 төгрөг буюу нийт 14925.0 мянган төгрөгийг зарцуулсан.		
1.1.2	Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж хог хаягдлаар бүрхэгдсэн талбайг багасгаж, орчны бохирдлыг бууруулах,	Нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж сумын иргэдийг хамруулж аян өрнүүлэн, цэвэрлэсэн	200 га талбай цэвэрлэсэн	Бүх нийтийн их цэвэрлэгээг хаврын улиралд зохион байгуулж 200 га талбайгаас дээш цэвэрлэх	Сумын хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг хавар намрын улиралд зохион байгуулсан. Суманд үйл ажиллагаа явуулдаг худалдаа үйлчилгээ, аж ахуйн нэгжийн нийт 86 албан байгууллагууд өөрийн эзэмшлийн хашааны орчмын 50 метр хүртлэх талбайн 75 тн хог хаядлыг цэвэрлэсэн. Мөн төсөвт байгууллагууд болон рашаан	2025.04.01 -2025.11.10	100

		талбайн хэмжээ			сувилалууд, усны үйлвэр, уурын зуухнууд нийт 31 аж ахуй нэгж байгуулагууд Хужирт гол дагуух нийтийн эзэмшлийн талбайн 274 га талбайн 212 тн хог хаягдлыг цэвэрлэсэн. 4, 5 дугаар багийн айл өрхүүдийн хашаа, гудамж, хорооны хог хаягдал цэвэрлүүлэх ажлыг 05 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Иргэдийн Хурлын төлөөлөгчид, иргэдтэй хамтран зохион байгуулж 46 га талбайн 337 тн хог хаягдлыг цэвэрлэсэн. Мөн шунхлай 5 дугаар багийн Гялгар гэх газарт байрлах хог хаягдлын цэгт тархсан хог хаягдлыг 10 дугаар сард бүрэн дарж булан ойр орчим хог хаягдалыг цэвэрлэх ажлыг төсөвт байгууллагууд болон рашаан сувилалууд, усны үйлвэр, уурын зуухнууд нийт 38 аж ахуй нэгж байгуулагууд хогийн цэгийн ойр орчмын 20 га талбайн 40 тн хог хаягдлыг цэвэрлэсэн Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд нийт 340 га талбайн 664 тн хог хаягдлыг цэвэрлэн төвлөрсөн хог хаягдлын цэгт тээвэрлэн буулгасан. Дээрх хугацаанд төвлөрсөн хог хаягдлын цэгт зам гаргах, хог хаягдлыг буулгах, дарж булах ажлыг 4 дүгээр багийн иргэн С.Жамбалжав ЗДТГ-ын ковшоор хийж гүйцэтгэсэн. Тус ажилд нийт 3.000.000 төгрөгийг байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулсан.		
1.1.3	Сумын төвлөрсөн хог хаягдлын цэгийг тохижуулах, хашаажуулж эзлэх талбайн хэмжээг багасгах ажлыг зохион байгуулах	Хог хаягдлын талбайн хэмжээг багасгах	Төвлөрсөн хог хаягдлын талбайн хэмжээг 1 удаа түрж багасгасан	Сумын хог хаягдлын нэгдсэн цэгийн талбайн хэмжээг 2 удаа түрж багасгах	Сумын төвийн хог хаягдлын цэгийн 1.2 га талбайд тархсан хог хаягдлыг 2025 оны 2-10 дугаар сарын хооронд нийт 6 удаа Шунхлай 5 дугаар багийн иргэн Б.Түвшинжаргал болон Өндөр-Сант хайрхан ХХК нь өөрийн 50-ковш, Хово автомашиныг ашиглан, 0.15 га талбай болгон хумиж, түрж цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.	2025.04.01 -2025.11.10	100
1.1.4	Малын сэг зэм, булаг шанд, голын эх ормын хог хаягдлыг	Малын сэг зэм, булаг шанд, голын эх ормыг	Жил бүр 100 тн-с доошгүй малын сэг зэм,	Малын сэг зэм, булаг шанд, голын эх ормыг	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн "Мал, амьтны сэг зэмийг цуглуулж, устгах, орчны	2025.04.01 -	100

	цэвэрлэн төвлөрсөн хаягдлын хүргүүлэн ажлыг байгуулах.	сумын хог цэгт устгуулах зохион	цэвэрлэн сумын төвлөрсөн хоягдлын цэгт буулгасан хогны хэмжээ	хог хаягдал цэвэрлэдэг	цэвэрлэн төвлөрсөн хог хаягдлын цэгт 120 тн-с доошгүй хог хаягдал буулгах	цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ажлын нэгдсэн удирдамж, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн 2025 онд хийх төлөвлөгөө батлах тухай” А/73 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх, арга хэмжээг зохион байгуулах тухай” А/242 дүгээр захирамж, Сумын Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт халдваргүйтгэл, сэг, зэм устгах арга хэмжээг зохион байгуулах тухай” А/29 дүгээр захирамж гарч хэрэгжилтийг зохион байгуулсан. Энэ жил нийт малын 0,6% буюу 1506 толгой мал зүй бусаар хорогдсон. Сэг, зэм устгалын ажлыг багийн Засаг дарга нараар ахлуулан малчдыг оролцуулан 5 дугаар сараас 10-ны өдрөөс эхлэн сэг зэмийг цуглуулах ажлыг зохион байгуулж нийт буюу хорогдлын 91,5%-ийг цуглуулж устгасан ба үүнээс адуу 335, үхэр 157, ямаа 414, хонь 470-ыг булшилсан. Сэг, зэм устгалын ажилд 32 хүн, техник хэрэгсэл 9 ажилласнаас 1 ковш, 4 ачааны машин, 4 суудлын машин ажиллаж 1,4 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан. Мөн 4300 м.кв талбайг халдваргүйжүүлсэн ба үүнээс хашаа хорооны 4200 м.кв, худасг уст цэгийн 100 м.кв талбайг халдваргүйжүүлсэн.	2025.05.20	
Зорилт 2: “УСНЫ НӨӨЦИЙГ ХАМГААЛАХ, ЗҮЙ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ЗАМААР ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ ХАДГАЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
1.2.1	Рашаан, усны зүй зохистой ашиглалт, хамгаалалтын бүс зэрэгт хяналт тавьж ажиллана.	Рашаан, усны зохистой ашиглалтанд хяналт тавьж, зөрчилд хариуцлага	Тухай бүр хяналт тавьж ажилласан.	Рашаан , усны зүй зохистой ашиглалтанд хяналт тавьж, хариуцлага тооцох	Өвөрхангай аймгийн Байгаль орчны газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч нартай хамтран БОУАӨЯ-ны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 01/07, 01/08 дугаартай удирдамжийн дагуу 6 рашаан сувиллын ус, рашааны ашиглалт, “Онги ус суваг” ОНӨААТҮГ-ын харьяа сумын төв	2025.01.01 - 2025.12.10	100	

		тооцох			цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд 2025.05.15-16-ны өдрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тус тус хийсэн. Хяналт шалгалтаар Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн 6 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээ авч ажилласан.		
1.2.2	Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартын шаардлага хангаж буй эсэхэд хяналт хийх	Шинжилгээний тоо	Улирал бүр шинжилгээнд хамруулж, стандартын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавин ажилласан	Цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэршүүлсэн уснаас шинжилгээтэй хяналт шалгалт 2-оос доошгүй удаа хийх	Суманд үйл ажиллагаа явуулж байгаа рашаан сувиллуудын бохир уснаас дээж авч аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний итгэмжлэгдсэн лабораторит 2 удаа шинжилгээнд хамруулж, стандартын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавин ажилласан.	2025.01.01 -2025.11.10	100
1.2.3	Сумын төвийн ундны усны худгуудаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулж, хяналт тавьж ажиллах.	Шинжилгээ авсан байдал	Жил бүр шинжилгээнд хамруулдаг	Сумын төвийн ундны усны худгуудаас дээж авч шинжилгээнд хамруулах	Сумын төвийн 4, 5 дугаар багийн цэвэр усны гүний худгуудаас хагас бүтэн жилээр 2 удаа дээж авч, Өвөрхангай аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лабораторид шинжилгээнд хамруулан ажилласан. Сорилтын дүнгээр MNS ISO 6222:1998, MNS ISO 19250:2017, MNS ISO 9308:1998 стандартын шаардлагыг хангасан. Сумын ИТХ-аар сумын ус хангамжийн эх үүсвэрийн худаг болон усан сан бүхий газрыг эрүүл ахуйн бүс тогтоож, орон нутгийн хамгаалалтад авч ажилласан.	2025.01.01 - 2025.12.10	100
Зорилт 3: “БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.3.1	1.3.1. Байгаль орчныг хамгаалах багц хуулиудын хэрэгжилтэнд хяналт тавих, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт	Байгаль орчныг хамгаалах багц хуулиудын хэрэгжилтэнд	Тухай бүр хяналт тавьж ажилласан.	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэдийн гомдол,	Хавар 3, 4 дүгээр сард Халиу бугын ясан эвэр унахтай зэрэгцэн хууль бусаар түүх, амьтны амьдрах орчныг алдагдуулж үргээж эцээх, үхэж үрэгдэх болон ой хээрийн түймэр гарах эрсдэлтэй байдаг бөгөөд тухайн хугацаанд 1, 2, 6 дугаар багуудад 14 удаагийн хяналт шалгалт хийж ажилласан.	2025.01.01 -2025.11.01	100

	хийх, зөрчлийг арилгах, хариуцлага тооцох.	хяналт тавьсан шалгалтын тоо шийдвэрлэсэн байдал.		мэдээллийн дагуу хууль хяналтын байгууллагуудт ай хамтран гүйцэтгэж хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.	Орхоны хөндийн байгалийн цогцолборт газар нутаг болох Орхон гол дагуу хууль бус загас агнуур, хууль бус мод бэлтгэл байгаль орчин хяналтын улсын байцаагч байгаль хамгаалагч нартай хамтран хяналт шалгалтыг 18 удаа зохион байгуулан ажиллаж байна. Зохих зөвшөөрлийн бичиггүй хууль бусаар шинэс болон хуш модыг бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хууль бус ан агнасан гэх 15 зөрчлийг илрүүлж Зөрчлийн тухай хуулиар торгох болон холбогдох байгууллага руу шилжүүлж хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан.		
1.3.2	1.3.2. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор байгаль орчны эрх зүйн сургалт, сурталчилгааг пэйж хуудсаар дамжуулах ажлыг зохион байгуулах;	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчил өмнөх оноос буурч, иргэдийн хандлага өөрчлөгдсөн байх, сургалт сурталчилгаан ы тоо	Байгаль орчны багц хууль түүнийг дагалдан гарсан дүрэм журмыг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг 50-аас доошгүй боршур зөвлөмжийг ард иргэдэд танилцуулсан.	Байгаль орчны багц хууль түүнийг дагалдан гарсан дүрэм журмыг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг цахим орчинд 20 постер, 100-аас доошгүй боршур зөвлөмжийг ард иргэдэд танилцуулан байгаль орчны эсрэг гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлсэн байна.	Засаг даргын Тамгын газрын фейсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх сонор сэрэмжтэй байх талаар зөвлөмж, мэдээллийг 8 удаа хүргэж ажилласан. Хууль бус мод бэлтгэл, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хууль бус мод бэлтгэл, ан агнуур, зориулалтын бус цэгт хог хаягдал хаях, ой, хээрийн гал түймэр гархаас урьдчилан сэргийлэх зэрэг зөвлөмжийг хөдөөгийн 543 иргэнд мэдээ мэдээлэл өгч брошур тарааж ажилласан. Хужирт цахим ТВ-ээр дамжуулан аж ахуйн нэгж байгууллага, айл өрх ард иргэдэд хог хаягдлын эх үүсвэр дээр нь хэрхэн ангилан ялгах, зориулалтын бус газар хог хаягдал хаяхгүй байх зэрэг дадал хэвшлийг мөрдүүлэх зорилгоор 14 удаагийн видео бичлэгийг хүргэж ажилласан байна.	2025.01.01 -2025.11.10	100
1.3.3	Иргэд олон нийтэд экологийн боловсрол олгох, байгаль орчны тэмдэглэлт	Сургалт сурталчилгаан ы тоогоор	Жил бүр байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд 5	Иргэд олон нийтэд экологийн боловсрол олгох зорилгоор Шивээт 4 дүгээр багийн нийтийн эзэмшлийн авто зам дагуу 2х3 мерийн хэмжээтэй 2 талт самбарт хог	2025.01.01 -2025.11.10	100

	өдрүүдийн хүрээнд төрөл бүрийн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах. АЗД, СЗД-тай байгуулсан гэрээний 9-р бүлгийн 1.2. дох заалт		хүрээнд төрөл бүрийн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан	төрлийн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	хаягдлыг эх үүсвэр дээр нь яаж ангилан ялгах заавар зөвлөмж, уриалга, мод бут тарих нь ямар ач тустай байх, ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээллийн самбар байршуулан ажилласан. Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх сумын иргэд, хүүхэд багачууд, айл өрхүүдийг анхан шатны эх үүсвэр дээр нь хог хаягдлыг ангилан ялгах дадал бий болгох, айл өрхүүдийг хог хаягдлыг ангилан ялгах жишиг хог хаягдлын савтай болгох хог хаягдлын менежментийг сайжруулах, мөн сумын төвийн шинээр бий болгох хог хаягдлын цэгийн байршлын санал асуулга хэлэлцүүлэг зохион байгуулж сургалтад нийт 300 иргэд хамрагдсан. Хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор иргэдийн нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж уг арга хэмжээнд шинэ хогийн цэгийн байршлыг сонгох, өрх бүр ангилан ялгах хогийн сав хийж хашаандаа байршуулах мөн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа өгч санал авч ажилласан.		
1.3.4	1.3.4. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа, мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулах:	Ойн сан бүхий газрын иргэдэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээллийн тоо	Ойн сан бүхий газарт нутагладаг 50 айл, өрхөд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хариуцлагын гэрээ байгуулан ажилласан.	Ойн сан бүхий газарт нутагладаг 70-аас доошгүй айл өрхөд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа, мэдээллийг хүргэсэн байна.	Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Ойн тухай хууль, Зөрчлийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж, Улсын Онцгой комиссын 01 дүгээр тушаал, албан даалгавар, аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнт эргүүл хийх зорилгоор Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид, Эрэн хайх, аврах бүлэг, багийн Засаг дарга нар хамтран Хужирт сумын ой сан бүхий Өвөр модот 1 дүгээр	2025.01.01 -2025.11.10	100

					багийн Зуслан, Хангийн мухар, Мөстийн гол, Цагаан хошуу, Хөндлөн, Нарийн гэх газруудын 30 айл өрхийн 116 иргэн, Уужим 2 дугаар багийн Уужим, Жаргалант, Бургас, Тээл, Мухдаг гэх газруудын 102 айл өрхийн 345 иргэн, Дулааны 6 дугаар багийн Хуурай, Шороот, Уруйт, Сарын гол гэх газруудын 27 айл өрхийн 82 иргэнтэй ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зөвлөмж брошур танилцуулж нийт 159 айл өрхийн 543 иргэнтэй хариуцлагын гэрээ байгуулж ажилласан. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар ил задгай хог хаягдал, өтөг бууц шатаасан болон үнс нурмаа зориулалтын тагтай саванд хийдэггүй, ил задгай жалганд асгадаг зэрэг 7 зөрчлийг илрүүлэн газарт дээр нь арилгуулах арга хэмжээ авч ажилласан. Ой сан бүхий газруудаар нутагладаг айл өрхүүдээр нийт 6 чиглэлд 4 авто машин 11 албан хаагч оролцож 656 000 төгрөгний шатахууны зардал зарцуулсан байна. ДАДЛАГА СУРГАЛТ Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх дадлага сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр тахим болон практикаар зохион байгуулсан. Дадлага сургалтыг Засаг даргын Тамгын газрын дарга З.Цэцэгмаа, Эрэн хайх, аврах бүлгийн дарга, Дэслэгч Өсөхбаатар Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Бямбасүрэн нар хариуцсан мэргэжлийн ангийн Эрэн хайх, аврах, гал унтраах бүлэг, хүнс, ус, дулаан хувцас, шатахуунаар хангах бүлгийн нийт 26 албан хаагчид оролцсон. Тахимын сургалтад Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Энхжаргал ой, хээрийн түймрийн үед хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, Эрэн хайх, аврах бүлгийн	
--	--	--	--	--	--	--

					дарга, Дэслэгч Өсөхбаатар ой, хээрийн гал түймрийн талаар ерөнхий ойлголт болон түймрийн үед авч хэрэгжүүлэх арга хамжээний талаар мэдээлэл өгсөн. Албан хаагчдийн аранзны бэлтгэл бэлэн байдлын үзлэгийг шалгаж, заавар зөвөлгөө өгч ажилласан. Практик сургалтын Шивээт 4 дүгээр багийн онгоцны буудал гэх газарт зохион байгуулж ой, хээрийн гал түймэр гарсан тохиолдолд шаардлагатай Зил 131 авто машин, ус нөөцлөх тонны 2 ширхэг сав, хүрз, жоотуу, говүүр, төмөр тороос, үлээгч багаж, шүршигч, усны помп, хөрөө зэрэг багаж хэрэгслийн бэлэн байдал, хэвийн ажиллагааг шалган хуурай 3 боодол өвс шатаан яаж унтраах талаар албан хаагчдад заавар зөвөлгөө өгч үр дүнтэй сургалт зохион байгуулж ажилласан. Сумын төвийн Шивээт 4 дүгээр багийн нийтийн эзэмшлийн авто зам дагуу иргэдэд ой хээрийн гал түймрээс гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээллийн самбар байршуулан ажилласан.		
1.3.5	Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, биотехникийн арга хэмжээ авах:	Биотехникийн арга хэмжээ авсан тоо	Дулаан 6-р багийн Сант хайрханд Уужим 2-р багийн Бургас, Тээл гэх газруудад нийт 5 удаа биотехникийн арга хэмжээ авсан байна.	Дулаан 6-р багийн Сант хайрханд 3-аас доошгүй, биотехникийн арга хэмжээ авсан байна.	Нэн ховор амьтад байршдаг газруудаар биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган багийн Засаг дарга нар болон нутгийн иргэдтэй хамтран 2025 оны 1-4 дүгээр саруудад 1, 2, 6 дугаар багийн нутаг дэвсгэрт давхардсан тоогоор нийт 12 цэгт 1.6 тн хужир тавьж өгөн биотехникийн арга хэмжээг авч ажилласан. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрийн зардлаас 1.8 сая төгрөгийг зарцуулсан.	2025.01.01 - 2025.06.10	100
1.4. ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМЫГ ТОДОРХОЙЛОХ, ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫН ШАЛТГААН ТОДРУУЛАХ ЗОРИЛГООР СУДАЛГАА ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ.							
1.4.1	Мэргэжлийн байгууллагатай	Ойн хөнөөлт хортон	7750 га талбайд	Ойн хөнөөлт хортон	Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг улсын	2025.05.01 -	100

	хамтран ойн хортон шавьжийн тандалт судалгаа хийж, устгалын ажлыг 1000-с дээш га талбайд хийх	шавьжийн тандалтыг тогтмол хийгдэнэ. Устгал хийх талбайн хэмжээ	хийсэн.	шавьжийн устгалын ажлыг 1000 дээш га талбайд хийнэ.	төсвийн хөрөнгөөр нийт 9,5 тонн хорыг 3000 га талбайд буюу Уужим 2 дугаар багийн Бургас Сэрт, Хуурай, Хавцгайт, Цагаан залаа, Ар өвөрт модот, Хойд хөндлөн, Хангийн энгэр, Тээл, Жаргалант зэрэг газруудад авиамикробиологийн аргаар хийсэн.	2025.07.10	
1.4.2	Агаар бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллогыг үнэн зөв судалгаа гаргаж холбогдох програмд оруулан чанартай зохион байгуулах	Агаар бохирдуулагчийн н эх үүсвэрийн судалгааг чанартай зохион байгуулсан байна.	Агаар бохирдуулагчийн н эх үүсвэрийн судалгааг чанартай зохион байгуулсан	Агаар бохирдуулагч аж ахуйн нэгж, айл өрхийн судалгааг бүрэн гаргаж холбогдох програмд оруулах УЦУОШГ-т хүлгээлгэн өгөх	Сумын Засаг даргын захирамжийн дагуу Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 2 дугаар сарын 15-ны өдрүүдэд 1 сарын хугацаанд зохион байгуулж, айл өрх, албан байгууллага нийт 853 агаар бохирдуулагч яндангийн судалгааг гарган холбогдох програмд шивж оруулсан. Сумын хэмжээнд нүхэн жорлонгийн тооллогыг зохион байгуулж, судалгаа УЦУОШГ-т хүлээлгэн өгсөн.	2025.02.01 - 2025.04.01	100
1.5. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ							
1.5.1	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд	Төрийн үйлчилгээний албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэн ажиллах	Тухай бүр тогтмол гаргаж, тайлагнасан.	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн эхний хагас жилийн биелэлт, хугацаатай тайлан мэдээг тогтмол гарган тайлагнах	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.	2025.01.01 - 2025.12.10	100

	хүргүүлэх						
1.5.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Хууль ёсны үүрэг даалгаврыг цаг тухай бүрт биелүүлэх	Тухай бүр тогтмол шийдвэрлэсэн.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу урд оны материалыг архивлан холбогдох албан хаагчид хүлээлгэн өгөх, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, хууль ёсны үүрэг даалгаврыг цаг тухайн бүрт нь биелүүлсэн. Нийт 23 өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн.	2025.01.01 - 2025.12.10	100
1.5.3	Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гаргасан тохиолдолд хариуцлага хүлээх;	Зөрчил дутагдалгүй ажиллах.	Зөрчилгүй ажилласан.	Зөрчилгүй ажилласан байна.	Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гаргаагүй ажилласан.	2025.01.01 - 2025.12.10	100
1.5.4	1.5.3 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж стандартыг биелүүлэх	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллаж ёс зүйн зөрчил гаргаагүй иргэдээс гомдол гараагүй байх	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, зөрчил гаргалгүй ажилласан.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж стандартыг биелүүлэх	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, зөрчил гаргалгүй ажилласан.	2025.01.01 - 2025.12.10	100

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Хувь
	1	2	3	4	5	6	7
1	Ажлын чиг үүрэгт хамаарал холбогдолтой чадавхижуулах сургалтанд тухайн бүр хамрагдах	Мэдлэг чадвараа дээшлүүлэх, чадвахжуулах сургалтын тоо	2 удаагийн сургалтанд хамрагдсан.	Өвөрхангай аймгийн БОАЖГ-аас зохион байгуулах сургалтуудад хамрагдах	Байгаль орчны газар, Сум дундын ойн ангиас 3 удаа зохион байгуулсан сургалтад хамрагдсан бөгөөд бие дааж, хууль дүрэм, журмыг судлан мэдлэг чадвараа дээшлүүлж ажилласан.	2025.01.01 - 2025.12.10	100
2	Арга хэмжээ 2. Бие даан Монгол бичгээр дүрмийн дагуу зөв бичих, унших чадвараа нэмэгдүүдлэх	Монгол бичгээр унших, бичих чадвараа дээшлүүлэх	Монгол бичгээр унших, бичих чадвараа дээшлүүлсэн.	Монгол бичгээр унших, бичих чадвараа сайжирсан байна.	Засаг даргын Тамгын газраас зохион явуулж байгаа Монгол бичгийн сургалтад хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлж байна.	2025.01.01 - 2025.12.10	100
3	Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох.	Олон нийтийн арга хэмжээнд хамрагдсан байна.	Зохион байгуулагдсан арга хэмжээ бүрд оролцсон.	Тухай бүр	Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй тогтмол оролцож байна.	2025.01.01 - 2025.12.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

..... /
Б.БЯМБАСҮРЭН/
(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)